



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-НИЙ 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/25/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Отгонхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дунд манхайдай аудит" ХХК
Захирал Ж.Бямбажав
Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	0
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
3.1 Компани, түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДЦС	Дулааны цахилгаан станц
НББ	Нягтлан бодох бүртгэл
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗХ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37. Факс (976-51) 26 42 30.
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.ДАШДАВАА ТАНАА

2025.03.17 № 07/1036
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус компани эрчим хүчний алдагдлыг бууруулах, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төсөл, хөтөлбөрийн нэгжийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн 124,241.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний урт хугацаат зээлийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна. Тухайлбал, Эрчим хүчний хөтөлбөр-1 төслийн 4,431.0 сая төгрөг, Эрчим хүчний төсөл хөтөлбөрийн 1,591.4 сая төгрөг, Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн 110,368.2 сая төгрөг, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн 1,278.9 сая төгрөг, Төвийн эрчим хүчний дамжуулалтын сүлжээг шинэчлэн засварлах төслийн 5,278.6 сая төгрөг, Шивээ-Овоо ХК-ийн нүүрсний уурхайн шинэчлэлийн МОН-Р5 төслийн 980.6 сая төгрөг, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д хэрэгжиж буй Эрчим хүчний дамжуулах үр ашгийг дээшлүүлэх төслийн 313.1 сая төгрөг.

Аудитын гол асуудал

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050", Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд 300 МВт-ын Бөөрөлжүүт цахилгаан станц, Газрын тос боловсруулах үйлдвэрийн өргөх станцын 110 кВ-ын 53.4 км цахилгаан дамжуулах агаарын шугам, Нарийн сухайт, Баян хөндийн 110 кВ-ын цахилгаан

дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил, Багануурын 50 МВт чадалтай Батарей хуримтлуурын станцыг Эрчим хүчний нэгдсэн системд залгах ажилд оролцсон байна.

Бусад асуудал

Улсын Их Хурлын 2010 оны 72 дугаар тогтоолоор хэрэгжиж дууссан урт хугацаат төслийн зээлийг анх авсан үеийн ханшаар тооцон төгрөгт шилжүүлж, зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг Сангийн яамтай тооцоо нийлсэн бөгөөд тайлант онд 867.0 сая төгрөгийн валютын ханшийн алдагдлыг тооцож, бүртгэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	4,119,213,255.75	2,545,319,186.01
1.1.2	Дансны авлага	1,286,948,641.25	6,002,968,179.66
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	218,968,759.61	310,884,997.37
1.1.4	Бусад авлага	587,262,975.26	1,403,822,095.20
1.1.6	Бараа материал	7,138,878,871.84	8,696,802,168.52
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	1,636,268,200.95	3,615,453,134.96
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	14,987,540,704.66	22,575,249,761.72
1.2.1	Үндсэн хөрөнгө	507,387,015,342.78	498,446,569,838.63
1.2.2	Биет бус хөрөнгө	34,579,189,327.08	62,416,990,427.96
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	680,706,153.14	628,344,141.36
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	115,578,051,734.63	273,979,080,441.15
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	658,224,962,557.63	835,470,984,849.10
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	673,212,503,262.29	858,046,234,610.82
2.1.1.5	Богино хугацаат зээл	871,339,046.06	8,167,000,043.50
2.1.1.6	Хүүгийн өглөг	16,691,455.99	15,239,367.87
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	62,038,210.98	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	526,589,607.35	772,869,961.35
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,476,658,320.38	8,955,109,372.72
2.1.2.1	Урт хугацаат зээл	123,905,532,133.59	279,590,106,525.71
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	1,564,299,725.98	1,343,818,779.47
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	255,448,087,753.60	252,206,141,008.83
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	380,917,919,613.17	533,140,066,314.01
2.2	Өр төлбөрийн нийт дүн	382,394,577,933.55	542,095,175,686.73
2.3.1	Төрийн өмч	238,073,068,351.04	238,073,068,351.04
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	45,985,469,154.04	45,946,677,439.64
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	33,667,158,220.00	61,087,415,220.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(26,907,770,396.34)	(29,156,102,086.59)
2.3.11	Эздийн өмчийн дүн	290,817,925,328.74	315,951,058,924.09
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	673,212,503,262.29	858,046,234,610.82

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	524,591,569,526.84	528,239,341,671.79
2	Борлуулалтын өртөг	531,750,572,711.92	533,404,568,391.15
3	Нийт ашиг (алдагдал)	(7,159,003,185.08)	(5,165,226,719.36)
4	Түрээсийн орлого	31,802,750.09	30,520,000.10
5	Хүүгийн орлого	30,470,249.49	36,908,730.08
8	Бусад орлого	14,883,191,923.72	26,462,691,594.09
10	Ерөнхий ба удирдлагын зардал	10,996,250,968.24	13,601,189,878.14
11	Санхүүгийн зардал	1,873,402,241.52	2,876,623,356.36
12	Бусад зардал	2,952,894,011.95	5,799,642,675.55
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	1,400,261,188.45	(866,979,340.62)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(19,775,069.19)	(454,710,567.26)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(6,655,599,364.23)	(2,234,252,213.02)
19	Орлогын татварын зардал	3,921,244.92	3,792,463.66
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(6,659,520,609.15)	7,577,917,102.82
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(6,659,520,609.15)	(2,238,044,676.68)
24	Орлогын нийт дүн	(6,659,520,609.15)	(2,238,044,676.68)

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	238,073,068,351.04	46,007,137,145.68	33,667,158,220.00	(20,433,174,824.29)	297,314,188,892.43
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	184,925,037.10	184,925,037.10
Залруулсан үлдэгдэл	238,073,068,351.04	46,007,137,145.68	33,667,158,220.00	(20,248,249,787.19)	297,499,113,929.53
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(6,659,520,609.15)	(6,659,520,609.15)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(21,667,991.64)	-	-	(21,667,991.64)
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	238,073,068,351.04	45,985,469,154.04	3,667,158,220.00	26,907,770,396.34	290,817,925,328.74
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(10,287,013.57)	(10,287,013.57)
Залруулсан үлдэгдэл	238,073,068,351.04	45,985,469,154.04	33,667,158,220.00	(26,918,057,409.91)	290,807,638,315.17
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	27,420,257,000.00	-	27,420,257,000.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(2,238,044,676.68)	(2,238,044,676.68)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(38,791,714.40)	-	-	(38,791,714.40)
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	238,073,068,351.04	45,946,677,439.64	1,087,415,220.00	(29,156,102,086.59)	315,951,058,924.09

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ний 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	144,573,940,653.44	179,155,305,762.66
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	70,904,544,291.07	85,590,634,190.26
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	155,906,312.00	183,197,551.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	73,513,490,050.37	93,381,474,021.40
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	141,984,629,329.41	183,716,044,016.77
1.2.1	Ажилсагсад төлсөн	36,312,908,462.54	49,209,036,456.82
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	11,614,969,063.04	15,338,772,426.94
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	6,073,272,126.59	14,511,954,275.13
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	402,195,018.19	402,875,666.74
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,217,513,591.60	2,236,164,971.88
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	95,450,987.38	14,359,497.07
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	77,666,383,804.67	79,051,492,668.83
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	55,819,274.44	156,840,643.87
1.2.9	Бусад мөнгөн зарлага	7,546,117,000.96	22,794,547,409.49
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,589,311,324.03	(4,560,738,254.11)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	85,892,798.03	58,303,699.91
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	55,422,548.54	21,394,969.83
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	30,470,249.49	36,908,730.08
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,086,244,801.49	3,744,089,187.70
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,079,314,801.49	3,744,089,187.70
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,930,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,000,352,003.46)	(3,685,785,487.79)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	13,056,522.74	9,273,823,470.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	11,807,869.16	9,273,375,228.86
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	1,248,653.58	448,241.14
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	274,634,963.48	2,601,193,797.84
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	271,453,867.51	2,600,696,403.75
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	3,181,095.97	497,394.09
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(261,578,440.74)	6,672,629,672.16
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,672,619,120.17)	(1,573,894,069.74)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,791,832,375.92	4,119,213,255.75
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,119,213,255.75	2,545,319,186.01

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Харьцуулалт			
						Төлөвлөгөөтэй		Өмнөх оны мөн үетэй	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тоо	Хувь	Тоо	Хувь
Дамжуулах цахилгаан эрчим хүч		сая.кВт.ц	7,777.4	8,310.0	8,330.1	20.1	0.2	552.7	7.1
Дамжуулалтын алдагдал	хувиар		3.6	3.7	3.7	(0.0)	(0.8)	0.1	3.2
	биетээр	сая.кВт.ц	276.2	307.0	305.4	(1.6)	(0.5)	29.2	10.6
Сонгино хуримтлуур		сая.кВт.ц	0.0	-	83.4	76.5	(6.9)	(8.2)	76.5
Дамжуулсан цахилгаан эрчим хүч		сая.кВт.ц	7,501.2	7,919.7	8,024.8	105.1	1.3	523.5	7.0
Нийт орлого		сая.төг	541,910.8	541,910.8	550,740.0	557,152.2	6,412.2	1.2	15,241.4
Үүнээс:	Үндсэн үйл ажиллагааны орлого	сая.төг	65,735.8	74,120.7	85,345.5	11,224.8	15.1	19,609.6	29.8
	Оюутолгой ХХК гэрээний орлого	сая.төг	458,855.7	458,328.8	442,893.9	(15,434.9)	(3.4)	(15,961.9)	(3.5)
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая.төг	17,319.2	18,290.5	28,912.9	10,622.4	58.1	11,593.6	66.9
Нийт зардал		сая.төг	548,566.4	548,566.4	569,797.0	559,386.5	(10,410.5)	(1.8)	10,820.1
Үүнээс:	Үндсэн үйл ажиллагааны зардал	сая.төг	85,764.5	105,971.0	106,988.5	1,017.5	1.0	21,224.0	24.7
	Оюутолгой ХХК гэрээний зардал	сая.төг	458,855.7	458,328.8	442,893.9	(15,434.9)	(3.4)	(15,961.9)	(3.5)
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая.төг	3,946.2	5,497.2	9,504.1	4,006.9	72.9	5,557.9	140.8
Элэгдэл		сая.төг	26,808.3	26,808.3	26,653.8	28,330.6	1,676.8	6.3	1,522.3
Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая.төг	(6,655.6)	(6,655.6)	(19,057.0)	(2,234.3)	16,822.8	(88.3)	4,421.3
Орлогын татварын зардал		сая.төг	3.9	3.9	-	3.8	3.8	-	(0.1)
Цэвэр ашиг алдагдал		сая.төг	(6,659.5)	(6,659.5)	(19,057.0)	(2,238.0)	16,819.0	(88.3)	4,421.5
Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал		төг	0.99	1.0	1.0	1.0	-	3.0	-
Нийт авлага		сая.төг	2,773.8	2,773.8	3,163.1	8,346.0	5,182.9	163.9	5,572.2
Үүнээс:	ЦЭХ	сая.төг	1,286.9	2,402.2	6,003.0	3,600.8	149.9	4,716.1	366.5
	Бусад	сая.төг	806.2	132.6	1,714.7	1,582.1	1,193.2	908.5	112.7
	Урт хугацаат авлага	сая.төг	680.7	628.3	628.3	-	-	(52.4)	(7.7)
Нийт өглөг		сая.төг	382,394.6	382,394.6	514,925.3	542,095.2	27,169.9	5.3	159,700.6
Үүнээс:	Богино хугацаат өглөг	сая.төг	1,476.7	20,008.5	8,955.1	(11,053.4)	(55.2)	7,478.4	506.4
	Урт хугацаат өглөг	сая.төг	380,917.9	494,916.8	533,140.1	38,223.3	7.7	152,222.2	40.0
Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая.төг	9,944.7	9,944.7	19,031.5	16,153.9	(2,877.6)	(15.1)	6,209.2
Нийт ажилтны тоо		хүн	1,286	1,286.0	1,305.0	1,299.0	(6.0)	(0.5)	13.0
Цалингийн сан		сая.төг	40,991.9	40,991.9	56,105.5	55,920.8	(184.7)	(0.3)	14,928.9
Нэг ажилтны дундаж цалин		төг	1,953.900	1,953.9	4,777.0	4,783.2	6.3	100.1	2,829.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн зорилгыг "Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, байгаль, орчинд ээлтэй, дэвшилтэд технологи ашиглан, цахилгаан эрчим хүчийг үр ашигтай дамжуулах үйлчилгээ үзүүлэх" гэж тодорхойлсон байна.

Тус компанийн дүрэмд дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Цахилгаан эрчим хүч дамжуулах;
- 0.4-220 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын угсралт, засвар, туршилт тохируулгын ажил гүйцэтгэх;
- 0.4-110 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах;
- Цахилгаан эрчим хүчний импортлох (БНХАУ-аас);
- Мэргэжлийн сургалт явуулах;
- Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах;

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК 10 хэлтэс, 1 төсөл хэрэгжүүлэх нэгж, Улаанбаатар болон Хангайн, Төвийн, Зүүн өмнөд, Говийн бүсийн орон нутгийн 5 салбарын хүрээнд 1299 ажилтантайгаар ажиллаж байна.

Өмчийн хувьд 100.0 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд Эрчим хүчний яам 66.0 хувийг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 34.0 хувийг эзэмшдэг байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг дүрмийн 9.2 дахь хэсэгт "ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна" гэж заасныг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 2, Эрчим хүчний яам 4, хараат бус 3, нийт 9 гишүүнтэйгээр томилсон байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал зардлыг 113.7 сая төгрөгөөр тогтоосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д "цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэж заасантай нийцэж байна.

Тус компани нь тайлант онд ТУЗ-ийн үйл ажиллагааны зардалд нийт 178.8 сая төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 154.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна. Үүнд: Цалин, урамшууллын зардалд 138.4 сая төгрөг, НДШ-ийн зардалд 16.0 сая төгрөг, бичиг хэрэг, бусад зардалд 0.4 сая төгрөг;

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн үйл ажиллагаандаа дараах эрх зүйн актыг мөрддөг байна. Үүнд:

- Эрчим хүчний тухай хууль
- Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль
- Компанийн тухай хууль

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын багц хууль

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- “Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох” Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоол.

Компанийн үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөгдөх санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 184,833.7 сая төгрөг буюу 27.5 хувиар өссөн байна.

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,119.2	2,545.3	(1,573.9)
Авлага	2,093.2	7,717.7	5,624.5
Бараа материал	7,138.9	8,696.8	1,557.9
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,636.3	3,615.5	1,979.2
Үндсэн хөрөнгө	507,387.0	498,446.6	(8,940.4)
Биет бус хөрөнгө	34,579.2	62,417.0	27,837.8
Урт хугацаат хөрөнгө оруулалт	680.7	628.3	(52.4)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	115,578.1	273,979.1	158,401.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	673,212.5	858,046.2	184,833.7
Богино хугацаат зээл	871.3	8,167.0	7,295.7
Хүүгийн өглөг	16.7	15.2	(1.5)
Урьдчилж орсон орлого	62.0	-	(62.0)
Бусад богино хугацаат өр төлбөр	526.6	772.9	246.3
Урт хугацаат зээл	123,905.5	279,590.1	155,684.6
Хойшлогдсон татварын өр	1,564.3	1,343.8	(220.5)
Бусад урт хугацаат өр төлбөр	255,448.1	252,206.1	(3,241.9)
Өмч-төрийн	238,073.1	238,073.1	-
Хөрөнгийн дахин үнэлгээ	45,985.5	45,946.7	(38.8)
Эздийн өмчийн бусад хэсэг	33,667.2	61,087.4	27,420.3
Хуримтлагдсан ашиг	(26,907.8)	(29,156.1)	(2,248.3)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	673,212.5	858,046.2	184,833.7

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,545.3 сая төгрөг болж, оны эхнээс 1,573.9 сая төгрөгөөр буурсан нь гэрээт ажлын баталгааны болон ажил үйлчилгээний төлбөрийг барагдуулснаас шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдэл оны эцэст 7,717.7 сая төгрөг болж, 268.7 хувиар өссөн байна. Үүнд: Нэмүү өртгийн албан татвар болон бусад авлага 91.9 сая төгрөгөөр, ААНОАТ-ын авлага 816.6 сая төгрөгөөр цахилгааны авлага 4,716.1 сая төгрөгөөр тус тус өссөн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлага дансны үлдэгдэлд Диспетчерийн үндэсний төвөөс цахилгаан дамжуулалтын үйлчилгээний хөлс (тариф)-ний 6,003.0 сая төгрөгийн, бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас авах 1,403.8 сая төгрөгийн авлагууд байна.

Цахилгааны авлага өссөн нь цахилгаан эрчим хүчний тарифыг 2024 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс өртөг буюу дутуу эх үүсвэрийг шийдвэрлэсэнтэй холбоотойгоор нэг худалдан авагчтай загварын арилжааны үйл ажиллагааг эрхлэн явуулдаг Диспетчерийн үндэсний төв ХХК-ийн тэг үлдэгдэлтэй орлогын нэгдсэн дансны мөнгөн урсгалын хувь өссөнтэй холбоотой байна. Энэ нь хэрэглэгчдийн орлого төвлөрүүлэлт дутуу буюу 85.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Өөрийн хөрөнгөөр 17,609.2 сая төгрөгөөр бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 16,051.3 сая төгрөгөөр бараа материал зарцуулсан байна. Бараа материалын үлдэгдэлд 8,696.8 сая төгрөгийн өртөг бүхий үндсэн сэлбэг болон аваарын нөөцийн бараа материал байна.

Урьдчилж төлсөн зардал дансанд жолоочийн хариуцлагын, тээврийн хэрэгслийн, гэнэтийн ослын даатгалын урьдчилгааны 27.6 сая төгрөг, шатахууны урьдчилгааны 14.1 сая төгрөг, Нарийн сухайт, Баян хөндий 110 кВ цахилгаан дамжуулах агаарын шугам, 2х16 Мега Вольт-Ампер дэд станцын төсөл, Оюутолгой ХХК-тай 220 кВ-ын ил хуваарилах байгууламжийн барилга угсралтын ажил

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

гүйцэтгэх, суурилуулах үйлчилгээний гэрээт болон бусад ажлын 3,573.7 сая төгрөгийн зардлууд бүртгэлтэй байна.

Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 23 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 6,701.5 сая төгрөгийн хөрөнгийг орлогод авч, өөрийн хөрөнгөөр 13,552.8 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу газар болон хөрөнгийг 27,428.3 сая төгрөгөөр үнэлж бүртгэсэн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 252, 667 албан бичгээр 214.3 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн, 2024 оны 278, 601 дугаар тогтоолоор 1,336.3 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Дуусаагүй үйлдвэрлэл дансанд Эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төслийн хүрээнд “Сонгино” батарей хуримтлуурын станцын ажлын 259,214.7 сая төгрөг, Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн ажлын 10,110.5 сая төгрөг, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний дуусаагүй ажлын 4,654.1 сая төгрөг, нийт 273,837.8 сая төгрөгийн дуусаагүй ажлууд бүртгэлтэй байна.

Богино хугацаат зээл дансны үлдэгдэл 8,167.0 сая төгрөг болж, 7,295.7 сая төгрөгөөр өссөн нь “Нэг худалдан авагч”-тай загварын орлого төвлөрүүлэлт 2024 оны гүйцэтгэлээр 85.7 хувьтай гарч, Голомт банкнаас 7,500.0 сая төгрөгийн зээл авсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансанд салбаруудын урт хугацаат зээлийн тайлант үед ногдох хүү, зээлийн өглөг 8,167.0 сая төгрөг, гэрээт ажлын 5 хувийн барьцааны төлбөрийн 772.9 сая төгрөг тус тус бүртгэлтэй байна.

Урт хугацаат өр төлбөр болон урт хугацаат зээл дансны үлдэгдэлд төсөл хөтөлбөрийн нэгжээс хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа төслийн үр дүнд бий болсон урт хугацаат зээл 279,590.1 сая төгрөгийн эрчим хүчний сүлжээнд ашиглах том чадлын хуримтлуурын төсөл, төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслүүд хэрэгжиж байгаа өр төлбөр байна. Төслийн үр дүнд бий болсон урт хугацаат зээлийн задаргааг хүснэгт 2-д харуулав.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн төсөл хөтөлбөрийн нэгжээс хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа төслийн үр дүнд бий болсон урт хугацаат зээлийн дүн 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 279,590.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Урт хугацаат зээлийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

д/д	Компанид хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн нэр	Зээлийн үлдэгдэл	Хөрөнгө оруулагч	Төсөл хэрэгжих хугацаа	Төслийн зорилго
1	Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжсэн Эрчим хүчний хэмнэлт төсөл	401.2	Олон улсын хөгжлийн ассоциаци	15	Эрчим хүчний алдагдал бууруулах
2	Германы СБЗ Банкны зээлээр хэрэгжсэн "Эрчим хүчний хөтөлбөр-1" төсөл (Багц-2)	1,289.6	ХБНГУ-ын КЕУЛ/ банкны зээл	33	Эрчим хүчний алдагдал бууруулах
	Германы СБЗ Банкны зээлээр хэрэгжсэн "Эрчим хүчний хөтөлбөр-төсөл (нэмэлт)	2,417.2	ХБНГУ-ын КЕУЛ/ банкны зээл	28	Эрчим хүчний алдагдал бууруулах
3	Шведийн олон улсын хөгжлийн агентлаг/ ЗЮА/-ын зээл, буцалтгүй	4,398.9	Шведийн Свенск	26	Эрчим хүчний

**Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

	тусламжаар хэрэгжсэн "Дамжуулах сүлжээний шинэчлэн засварлах төсөл		Экспорт кредит корпорац		алдагдал бууруулах
4	Япон улсын Засгийн газрын хөнгөлөлтэй зээлийн хөрөнгөөр "Багануур", "ИМвээ-Овоо" хувьцаат компанийн нүүрсний уурхайг шинэ чилэх "МОН П-5"төсөл	785.9	Японы олон улсын хамтын ажиллагааны банк	21	Цахилгааны хэмнэгт
5	Том чадлын хуримтлуур /013874/төсөл	259,979.7	Азийн хөгжлийн банк	14	Цахилгаан +хуримтлуур
6	Дэлхийн банкны 6102 МИ төсөл	1,595.2	Улаанбаатар дулааны сүлжээ	33	Цахилгаан хэмнэлт төсөл
7	"УБЦТС" ХК-ийн Дэлхийн банкны эрчим хүчний анхны төсөл болон нэмэлт санхүүжилтийн төсөл	216.7	УБЦТС ТӨХК	19	Эрчим хүчний дамжуулах үр ашгийг дээшлүүлэх
8	Төвийн эрчим хүчний дамжуулалтын сүлжээг шинэчлэн засварлах	8,505.6	ХБНГУ-ын КЕВЛ/ банкны зээл	15	Дамжуулах үр ашгийг дээшлүүлэх
НИЙТ ДҮН		279,590.1			

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 45,946.8 сая төгрөг болж, 38.8 сая төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 278, 601 дугаар тогтоолоор 427 нэр төрлийн 1,336.3 сая төгрөгийн анхны өртөгтэй, 1,206.6 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг акталж данснаас хасаж, актлагдсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн 21.7 сая төгрөгийн гарзыг хүлээн зөвшөөрсөн нь нөлөөлсөн байна.

Хуримтлагдсан ашиг данс тайлант үеийн алдагдлаас шалтгаалсан 2,248.3 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, Эрчим хүчний сайдаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/22 дүгээр тушаалаар 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд нийт орлогыг 556,226.2 сая төгрөгөөр, зардлыг 577,002.9 сая төгрөгөөр, алдагдлыг 20,776.7 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Эрчим хүчний сайдын 2024 оны 09 дүгээр сарын 03-ний өдрийн А/183 дугаар тушаалаар зорилтот түвшний төлөвлөгөөг тодотгон нийт орлогыг 550,740.0 сая төгрөгөөр, зардлыг 569,797.0 сая төгрөгөөр, алдагдлыг 19,057.0 сая төгрөгөөр баталсан байна.

Тус компани 8,330.1 сая кВт.цаг цахилгаан эрчим хүчийг дамжуулалтад авсан нь төлөвлөснөөс 0.2 хувь буюу 20.1 сая кВт.цагаар, өмнөх оны мөн үеэс 7.1 хувь буюу 552.7 сая кВт.цагаар нэмэгдсэн байна.

Цахилгаан эрчим хүчний дамжуулалтын дотоод хэрэглээ, техникийн алдагдалд 3.67 хувь буюу 305.4 сая кВт.цаг зарцуулахаас, төлөвлөгөөнөөс 0.03 пунктээр буурсан байна.

Тайлант хугацаанд нийт 557,152.2 сая төгрөгийн орлоготой ажиллаж, төлөвлөгөөнөөс 6,412.2 сая төгрөг буюу 1.2 хувиар, өмнөх оны мөн үеэс 15,241.4

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

сая төгрөг буюу 2.8 хувиар өссөн байна. Дамжуулалтын орлогоос 85,345.5 сая төгрөг, Оюутолгой ХХК-тай цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний дагуу 442,893.9 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 28,912.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр нийт зардал 559,386.5 сая төгрөгт хүрч, 2,234.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт зардлаас тайлант онд баталсан төсвөөс үндсэн ба нэмэгдэл цалингийн зардлыг 184.7 сая төгрөгөөр, дулааны зардлыг 79.5 сая төгрөгөөр, тээврийн зардлыг 67.4 сая төгрөгөөр, албан томилолтын зардлыг 118.1 сая төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын зардлыг 183.8 сая төгрөгөөр дутуу зарцуулж, урсгал засварын зардлыг 22.6 сая төгрөгөөр, тэтгэмжийн зардлыг 199.4 сая төгрөгөөр, элэгдлийн зардлыг 1,676.8 сая төгрөгөөр, санхүүгийн зардлыг 279.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

Хэмнэлтийн горимд шилжин үндсэн үйл ажиллагааны 20 гаруй нэр төрлийн зардалд хуулийн хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг авч тайлант онд 992.2 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

Үндсэн үйл ажиллагааны зардал 1,017.5 сая төгрөгөөр буюу элэгдлийн зардал 1,676.8 сая төгрөгөөр өссөн нь төлөвлөгөөнд 28,211.0 сая төгрөгийн санал хүргүүлсэн боловч хяналтын явцад хасагдсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн бус үйл ажиллагааны зардал 4,006.9 сая төгрөгөөр өссөн нь компанид хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус алдагдал нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд их засварын 216, техник зохион байгуулалтын арга хэмжээний 41, хөрөнгө оруулалтын 56 нийт 313 нэр төрлийн ажилд 19,031.5 сая төгрөгийг төлөвлөн, гүйцэтгэлээр их засварын 203, техник зохион байгуулалтын арга хэмжээний 41, хөрөнгө оруулалтын 45, нийт 289 нэр төрлийн ажилд 13,211.4 сая төгрөг, өмнөх оны ажилд 2,882.5 сая төгрөг, нийт 16,153.9 сая төгрөгийг зарцуулж, 84.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК, түүний гадаад, дотоод орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, цалин, зардал, худалдан авах ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дунд Манхайдай аудит ХХК-ийн ахлах аудитор Н.Тэмүүжин, аудитор Н.Гантөмөр нар гүйцэтгэж, захирал Ж.Бямбажав хянан удирдаж, чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа анхан шатны чанарын хяналтыг, Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор С.Отгонхоролоо, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 01/134 дугаар албан бичгээр Дунд Манхайдай аудит ХХК-д ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 547,573.1 сая төгрөгийн 1.5 хувиар тооцож, 5,475.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын батлагдсан бүтэц орон тоог шинэчлэн, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК 2024 онд шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгоогүй, цалингийн зардлыг 184.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Цахилгаан эрчим хүчний дамжуулалтын дотоод хэрэглээ, техникийн алдагдалд 3.67 хувь буюу 305.4 сая кВт.цаг зарцуулж, төлөвлөгөөнөөс 0.03 пунктээр буурсан байна.

Тайлант онд 557,152.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 559,386.5 сая төгрөгийн зардал гаргаж, татварын дараах 2,238.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, алдагдлын түвшнийг 16,819.0 сая төгрөг буюу 88.3 хувиар бууруулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 1,467.0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, зөрчлийн арилгуулахаар 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт 1. Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг мөнгөн хөрөнгийн дансны журнал, харилцах дансны хуулгатай тулгахад 158.5 сая төгрөгийн 19 гүйлгээг дутуу мэдээлсэн, 743.1 сая төгрөгийн 11 гүйлгээний банкны харилцах дансны дугаарыг зөрүүтэй оруулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 20.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 565.4 сая төгрөгийн бараа материалыг шилэн дансны худалдан авалтын тайланд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжид, Төрийн хэмнэлтийн болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилт нь холбогдох хууль, тогтоомжийн заалтуудтай нийцээгүй гэж дүгнэлээ.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус компанийн 2024 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулан мөнгөн хөрөнгө, бараа материал, авлага данстад горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 76,284.8 сая төгрөгийн 8 алдаа, зөрчил илрүүлж, залруулах зөвлөмжийг асуудлын бүртгэлээр танилцуулж, баталгаажууллаа. Жилийн эцсийн аудитаар залруулга хийсэн эсэхийг дахин нягталж, аудитын тайланд залруулгаар тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/101 дугаар албан бичгээр ҮАГ-т ирүүлж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 01/1070 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Аудитын явцад биелэлтийг хянаж үзэхэд 22.0 сая төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 182.3 сая төгрөгийн 4 албан шаардлага, 1,514.2 сая төгрөгийн 6 зөвлөмжийг хэрэгжүүлж, 378.6 сая төгрөгийн 1 зөвлөмж хэрэгжилтгүй, биелэлт 82 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	4	22.0	4	22.0	-	-	100.0
Албан шаардлага	4	182.3	4	182.3	-	-	100.0
Зөвлөмж	7	1892.8	6	1514.2	1	378.6	80.0
Нийт дүн	15	2,097.1	14	1,718.5	1	378.6	82.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материал дансны үндсэн сэлбэг хэрэгслийн 1-2 жил хөдөлгөөн гараагүй үлдэгдлийн судалгаа хийж ангилах, ашиглагдахгүй байгаа сэлбэгийг тодорхойлон, биет тест хэрэгжүүлэх, Диспетчерийн үндэсний төв Төрийн өмчит ХХК-аас авах цахилгаан дамжуулсан үйлчилгээний 6,002.9 сая төгрөгийн авлагыг барагдуулсан эсэх, салбар хоорондын тооцоог баталгаажуулсан байдалд хяналт хэрэгжүүлэх, төлөвлөгөөнд тусгаагүй бараа материалыг шууд худалдан авсан зөрчлийг таслан зогсоож арга хэмжээ авсан талаарх асуудлуудыг авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 76,284.8 сая төгрөгийн 8 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав.

Залруулсан алдаа:

- Мөнгөн хөрөнгийн данснаас ажилчдад олгосон сургалт, мөнгөн тусламж дэмжлэгийг дараа тайлангийн тооцоонд бүртгэхгүйгээр 342.6 сая төгрөгийг шууд зардлын дансанд бүртгэсэн;
- Авлагын данснаас цайны газрын хүнсний барааг барааны дансаар бүртгэхгүйгээр 0.8 сая төгрөг зардлын дансанд бүртгэсэн;
- Бараа материалын ангиллаар "хангамжийн зүйлс"-д хамаарах шинж чанартай хөрөнгийг үндсэн сэлбэг хэрэгслийн дансанд 39.4 сая төгрөг бүртгэсэн;
- Бараа материалын данснаас өртөг, зардлын дансанд зарлагадсан багаж тоног төхөөрөмжийг дахин хянаж холбогдох хөрөнгийн дансанд 98.0 сая төгрөг, Улаанбаатар салбар, Хангайн бүсийн салбар нь 1.7 сая төгрөгийн өртөгтэй Старлинк Gen 2 төхөөрөмжийг зардалд бүртгэсэн;
- Дамжуулалтын үйлчилгээний орлого /импорт/ дансанд бүртгэх 6, 9-р сарын 75,661.9 сая төгрөгийн гүйлгээний дүнг Дамжуулах үйлчилгээний орлого дансанд бүртгэсэн;
- НӨАТ төлөгч 7 компанийн Худалдан авалтын Е-баримтаар 13.8 сая төгрөгийн бараа материалыг НӨАТ-ын дүнг нэмж орлого авсан;
- Мишээл консалтинг ХХК-д өмгөөллийн төлбөрт шилжүүлсэн 6.6 сая төгрөгийн дүнг 13.1 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- Саруул гоулд ХХК-д Оюутолгой дэд станцын гэрээт ажлын урьдчилгаанд шилжүүлсэн 1,320.0 сая төгрөгөөс хасалт хийгээгүй 120.0 сая төгрөгийн НӨАТ-ын авлагын тооцоог давхардуулан бичилт хийн бүртгэсэн.

Аудитаар нийт 3,684.7 сая төгрөгийн зөрчлийг² илрүүлж, зөрчлийг нөхөн төлүүлэхээр 17.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгуулахаар 1,530.8 сая төгрөгийн 8 албан шаардлага, 2,136.9 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 3,684.7 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгөхөөр шийдвэрлэв.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1. Улаанбаатар салбар нь нэр бүхий 2 аж ахуйн нэгж, байгууллагад шинэ жил барааны үнийн төлбөрт нийт 15.5 сая төгрөгийг нотлох дэмжих баримтгүйгээр шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх", 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нотлох дэмжих баримтгүйгээр шинэ жил барааны үнийн төлбөрт шилжүүлсэн 15.5 сая төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хяналтын шалгалтын орлогын 100900000601 дүгээр дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 2 Тайлант хугацааны шатахуун зарцуулалтын тайланг шалгахад компанийн хөрөнгөд бүртгэлгүй хувийн автомашинд тушаал, шийдвэргүйгээр 1.5 сая төгрөгийн шатахуун олгож зарцуулсан байна.

Энэ нь "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн хөрөнгөд бүртгэлгүй хувийн автомашинд тушаал, шийдвэргүйгээр шатахуун олгосон 1.5 сая төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын хяналтын шалгалтын орлогын 100900000601 дүгээр дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Меса Инженеринг ХХК төмөр бетон тулгуур нийлүүлэх 2023/203 дугаар гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй байхад 6.8 сая төгрөгийн алдангийг тооцохгүйгээр төлбөрийг шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "үр ашигтай байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй, алданги тооцоогүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Төвийн бүсийн салбар нотлох, дэмжих баримтгүйгээр 14.7 сая төгрөгийг баярын хурлын заалны түрээсийн төлбөрт зарцуулсан байна.

Энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх", 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.2.3-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж заасныг тус тус байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй, нотлох, дэмжих баримтгүй, зориулалтын бус зардлыг санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Бараа материалын дансанд 20 нэр төрлийн 1,269.9 сая төгрөгийн төгрөгийн Үндсэн сэлбэг хэрэгслээс 2 жил хөдөлгөөн гараагүй 333.9 сая төгрөгийн сэлбэгийн үлдэгдэл нөөц үүссэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын үлдэгдэлд бүртгэлээр хяналт тавьж, нөөц үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

